



СОЁМБО МЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№252 /461/

Цаг үе, үйл явдал

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ УДИРДАХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ СТРАТЕГИЙН ЦУГЛАРАЛТ ЭХЭЛЛЭЭ



Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний 2023 оны стратегийн цугларалт энэ сарын 23-25-ны өдрүүдэд “Монгол Улсын аюулгүй байдлын орчин ба Батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бэхжүүлэх бодлогын шинэчлэл” сэдвийн хүрээнд зохион байгуулагдаж байна.

Цугларалтад ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар, БХЯ-ны СБТГ-ын дарга хурандаа Ч.Гандирваа, ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга хурандаа Ж.Өсөхбаяр, орлогч дарга хурандаа

Т.Галбадрах, орлогч дарга, ЦТГ-ын дарга хошууч генерал А.Ганбат, тэргүүн ахлагч Н.Баасан, ҮАБЗ-ийн стратегийн судалгааны хүрээлэнгийн зөвлөх Р.Болд тэргүүтэй Зэвсэгт хүчний удирдах албан тушаалтнууд оролцож байна.

Ө.НАСАНТОГТОХ

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-29	-42

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	23

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.486	3.492
EUR	3.805	3.820
CNY	512	515
RUB	49.20	49.50
JPY	27.10	27.35
KRW	2.82	2.85

ЗУРХАЙ

2022.01.23 / ДАВАА ГАРАГ / БИЛГИЙН ТООЛЛЫН 2

ӨВЛИЙН АДАГ ХАРАГЧИН ҮХЭР САР
ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ
ЦАГААГЧИН МОГОЙ ӨДӨР

Үс засуулбал:
Хэрүүл тэмцэл ирнэ
Наран ургах, шингэх:
08.31-17.37
Барилдлага:
Рашаан
Шүтэн барилдлага:
Хуран үйлдэхүй

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Эл өдөр насны хүч дэлгэрнэ. Эм найруулах, угаал үйлдэх, бэр авах, насны авшиг, насны бүтээл хийх зан үйл хийгээд төрөл садан бололцох, худалдаа наймааны үйлнээ сайн болой, үсэг зурхайд суралцах, бэрийн болон буяны үйл, дайсныг дарахад сайн. Зүүн нүд татвал үзэсгэлэн болох, баруун нүд татвал үйл өчүүхэн бүтэх, баруун чих хангинавал гоо болох, зүүн чих хангинавал сайн. Нохой уливал хааны хэрэг болох, хэрээ дуугарвал өөрийн цусыг үзэх, тагнай загатнавал гэрт үзэсгэлэн болох, бүх бие татвал эд алдах, хөлийн мах татвал сайн гэдэг.

ЯПОН УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХЫН АТТАШЕГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ



Зэвсэгт хүчний Жанжин штабын Цэргийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга хурандаа Ж.Молорболд Япон Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Батлан хамгаалахын атташе дэд хурандаа Ирики Ёохэйн хүсэлтийн дагуу 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр хүлээн авч уулзлаа.

Уг уулзалтаар 2023 онд зохион байгуулагдах Хааны эрэлд олон улсын хамтарсан сургуульд Япон Улсын талаас оролцох оролцоо болон цэргийн бусад хамтын ажиллагааны арга хэмжээний талаар харилцан санал солилцсон юм.



ИНЖЕНЕРИЙН ДАЙЧИД ҮНДЭСНИЙ ӨВ СОЁЛ, УЛАМЖЛАЛАА СУРТАЛЧИЛЛАА



Цэргийн гавьяаны Улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 014 дүгээр анги 2022-2023 оны сэтгэл зүйн хангалтын төлөвлөгөөний дагуу Инженер техникийн албанаас 01 дүгээр сарын 20-ны өдөр үндэсний өв соёл, дуу хуур, тоглоом наадгай, түүх шаштир, утга зохиол, бичиг соёлын өв уламжлалыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах зорилгоор “Цагаан сар Монгол түмний их баяр” тэмцээнийг алба, салбаруудынхаа дунд зохион байгуулж явууллаа.

Тэмцээнд зургаан баг мэндчилгээ, заавал дуулах дуу, АХА, “Дэмбээ” наадгай, Халх ардын дуу гэсэн 5 болзлоор өрсөлдснөөс тэргүүн байрт ангийн удирдлага, штаб, Ажиллагааны удирдлагын тасгийн “Туургатан”,

дэд байрт Инженер сапёрын батальоны “Есөн Эрдэнэ”, гутгаар байрт Үлээвэр найрал хөгжим, харуулын салааны “Хар хөг” багууд тус бүр манлайлав.

“Шилдэг дуучин” төрөлд “Арван тавны сар” дуугаар ахлах дэслэгч О.Баатархүү, “Шилдэг дэмбээчин”-ээр ахлах байлдагч Э.Мөнхбаатар, “Шилдэг үндэсний хувцастай алба хаагч”-аар ахлах ахлагч Б.Баярбат, тогооч Ё.Цэенханд нар шалгарч, өв соёл уламжлалаа сурталчлав.

Энэхүү тэмцээн нь Зэвсэгт хүчний Жанжин штабаас ирэх хоёрдугаар сард зохион байгуулах “Цагаан сар-Монгол түмний уламжлалт их баяр”-т оролцох авьяаслаг бүрэлдэхүүнийг шалгаруулахад чиглэсэн юм.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 673,327,781

Эдгэрсэн

Нийт: 645,190,678

Нас барсан

Нийт: 6,746,388

Цахим шууданд

АХЛАХ АХЛАГЧ Э.ДАВААЖАМЦ ХЭТ ХҮЙТНИЙ ҮЕИЙН НӨХӨРСӨГ ГҮЙЛТЭД ОРОЛЦОНО



Монгол Улсын хэт холын марафон гүйлтийн зарим ахмад тамирчин, рекорд эзэмшигчид маргааш буюу 1 дүгээр сарын 23-ны үүрээр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд гүйхээр төлөвлөжээ. Энэ нь газрын хөрсөндөө хасах 45 хүртэл хүйтэрнэ гэсэн мэдээ байгаа учир марафон гүйгчид "Хүйтэн цаг агаарын гүйлт" хэмээх нөхөрсөг арга хэмжээг зохион байгуулах гэж буй ажээ.

Гүйгчдийн дунд Нобелийн шагналт багийн гишүүн, олон улсын зэвсгийн шинжээч, гүйлтийн спортын мастер, доктор профессор, бэлтгэл хурандаа Д.Эрдэнэцогт болон Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн хөгжимчин, Монгол Улсын олон өдрийн ганцаарчилсан гүйлтийн


рекорд эзэмшигч, спортын мастер, ахлах ахлагч Э.Даваажамц нар багтсан байна.

Энэ талаар ахлах ахлагч Э.Даваажамцаас тодруулахад "Гүйлтээр хичээллэгч ах эгч, найз нөхөд маань ийм санал тавьсны дагуу зөвшөөрсөн. Энэ бол уралдаан биш нөхөрсөг гүйлт. Оролцох нь хамгийн чухал. Аагим халуун, аадар бороо, хүчтэй салхийг ч үл тоож Ховд аймгаас Чойбалсан хот хүртэл 46 хоног тасралтгүй гүйсэн хүний хувьд надад сонирхолтой санагдаж байна. Миний хувьд орон нутагтаа нийтийн биеийн тамирыг сурталчлах, хүүхэд, залуучуудад марафон гүйлт, ууланд авирах дадал, зуршлыг бий болгох, эрүүл мэндийн

шалтгаантай хүмүүст дасгал хөдөлгөөнөөр эрүүлжихэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор клуб байгуулан ажиллаж байна. Ажлын бус цагаар, амралтын өдрүүдэд дасгал, сургалтаа явуулж, гүйх болон ууланд алхах арга техникийг хүүхэд багачуудад заадаг" гэв.

Ташрамд онцлоход, ахлах ахлагч Э.Даваажамц нь 2021 онд монгол цэргийн тэсвэр хатуужил, эр зоригийг батлан харуулж 46 хоног гүйхдээ дэмжигч байгууллага, иргэдийн зүгээс хандивласан мөнгөн тусламжаар Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв болон Ховд аймгийн Бүсийн оношилгооны төвд хүчил төрөгчийн аппаратуудыг хандивлаж байсан юм.

Ахмад Д.БОЛОР



Цаг үе, үйл явдал

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 2023 ОНЫ ӨВЛИЙН СПОРТЫН АВАРГУУД ТОДОРЛОО

Зэвсэгт хүчний 2023 оны аварга шалгаруулах Цэрэгжлийн спортын өвлийн 2 төрөлт, Цэрэг спортын цогцолборын олон төрөлтийн тэмцээн 1 дүгээр сарын 16-20-ны өдрүүдэд байгаль цаг агаарын хүндрэлтэй нөхцөлд амжилттай явагдаж өндөрлөв.

Тэмцээний Ерөнхий шүүгч, ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын Биеийн тамир, спортын тасгийн дарга, хурандаа Д.Цог-Эрдэнэ цаг агаарын эрс хүйтэн нөхцөлд явагдсан нь цэргийн алба хаагчдын тэсвэр хатуужлыг бодитоор шалгахын зэрэгцээ бэлтгэж сургах, дадлагажуулах нэг хэлбэр нь байсныг тодотгов.

Тэмцээний хаалтын ёслол 1 дүгээр сарын 20-ны өдөр Зэвсэгт хүчний Хужирбулан дахь Сургалтын төвд зохион байгуулагдаж, ЗХЖШ-ын орлогч дарга, хурандаа Т.Галбадрах, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч, бригадын генерал Ч.Цогтжаргал, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч, хурандаа Т.Ганбат, ҮБХИС-ийн захирал, бригадын генерал П.Жаргалан, Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэргийн штабын дарга, хошууч генерал Л.Гансэлэм нарын ЗХЖШ, төрлийн цэргийн командлалын удирдлага, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн захирагч нар оролцсон юм. Ингээд тэмцээний дүнг та бүхэндээ танилцуулъя.

Биатлоны хувийн дүнгээр:
-Тэргүүн байрт спортын мастер, түрүүч Э.Энхсайхан (326)
-Дэд байрт ОУХМ, ахлагч О.Гантулга (337)
-Гутгаар байрт ахлагч Ц.Сүрмаа (310)
Биатлоны багийн дүнгээр:
-Тэргүүн байрт Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн дэд ахлагч Б.Мөнхзул, спортын мастер, дэслэгч У.Батжаргал,
-Дэд байрт Зэвсэгт хүчний 186 дугаар хугацаат цэргийн алба хаагч, байлдагч Ц.Төгөлдөр, цэргийн гэрээт алба хаагч, цэрэгжлийн спортын мастер, дэд түрүүч Т.Мөнх-Эрдэнэ,
-Гутгаар байрт Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн цэрэгжлийн спортын мастер, ахлагч Э.Мөнх-Эрдэнэ, дэслэгч Б.Батзаяа нар тус тус шалгарлаа.

"Патруль"-ийн төрөлд:
-Тэргүүн байрт Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн цэрэгжлийн спортын

мастер, ахлагч С.Эрдэнэтовч, спортын мастер, ахлагч Э.Мөнх-Эрдэнэ, дэслэгч Б.Батзаяа, цэрэгжлийн спортын мастер, ахлах дэслэгч М.Цэрэндорж,
-Дэд байрт Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн спортын дэд мастер, ахлагч Б.Дорждэрэм, спортын дэд мастер, ахлагч Ж.Буяндэлгэр, цэрэгжлийн спортын мастер, дэслэгч Х.Гийх-Оргил, ахлагч Л.Ням-Очир,
-Гутгаар байрт Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн дэд ахлагч Г.Чойсүрэн, дэд ахлагч Б.Мөнхзул, цэрэгжлийн спортын мастер, ахлах ахлагч Р.Ганхуяг, спортын мастер, дэслэгч У.Батжаргал нар тэргүүлээ.

Өвлийн 2 төрөлтийн байгууллагын нийлбэр дүнгээр тэргүүн байрт хурандаа Н.Бат-Эрдэнэ захирагчтай Зэвсэгт хүчний 330 дугаар анги, дэд байрт хурандаа Ш.Гантулга захирагчтай Зэвсэгт хүчний 015 дугаар анги, гутгаар байрт дэд хурандаа Б.Өлзийдэлгэр захирагчтай Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн баг тамирчид шалгарсан юм.

Цэрэг спортын цогцолборын өвлийн олон төрөлтийн тэмцээний 18-30, 31-35, 36-40, 41-ээс дээш насны ангилалд дараах тамирчид тэргүүлэв.

18-30 насны эрэгтэйчүүдийн төрөлд:
-Тэргүүн байрт ОУХМ, ахлагч О.Гантулга (337)
-Дэд байрт дэд ахлагч Д.Жайсан (065)
-Гутгаар байрт спортын мастер, ахлагч Н.Алтаншагай (011)

18-30 насны эмэгтэйчүүдийн төрөлд:
-Тэргүүн байрт спортын мастер М.Должинсүрэн (326)
-Дэд байрт спортын мастер, ахлагч Э.Ариунзул (311)

-Гутгаар байрт цэрэгжлийн спортын мастер, ахлагч О.Уранбайгаль (186)
31-35 насны эрэгтэйчүүдийн төрөлд:

-Тэргүүн байрт ахмад С.Алтынбек (353)
-Дэд байрт цэрэгжлийн спортын мастер, ахмад М.Цэрэндорж (330)
-Гутгаар байрт цэрэгжлийн спортын дэд мастер, ахлах ахлагч Ц.Цогтдэлгэр (326)

31-35 насны эмэгтэйчүүдийн төрөлд:
-Тэргүүн байрт ОУХМ, ахлах ахлагч Ч.Отгонцэцэг (065)
-Дэд байрт ОУХМ, ахмад Н.Ууганцэцэг



(311)
-Гутгаар байрт ахлагч С.Баярцэцэг (016)
36-40 насны эрэгтэйчүүдийн төрөлд:
-Тэргүүн байрт цэрэгжлийн спортын мастер, ахлах ахлагч Б.Баярсайхан (150)
-Дэд байрт цэрэгжлийн спортын мастер, хошууч Б.Хэнзээ (015)
-Гутгаар байрт цэрэгжлийн спортын дэд мастер, ахлах ахлагч С.Эрдэнэбилэг (326)
36-40 насны эмэгтэйчүүдийн төрөлд:
-Тэргүүн байрт ахлах ахлагч Б.Баярцэцэг (037)
-Дэд байрт ахлах ахлагч Д.Сүрэнхорлоо (013)
-Гутгаар байрт ахлах ахлагч Н.Эрдэнэсүвд (119)
41 наснаас дээш эрэгтэйчүүдийн төрөлд:
-Тэргүүн байрт сургагч ахлагч Б.Мөнгөн-Өлзий (186)
-Дэд байрт цэрэгжлийн спортын мастер С.Баттулга (119)
-Гутгаар байрт цэрэгжлийн спортын дэд мастер, ахлах дэслэгч Б.Баасанцэрэн (350)
41 наснаас дээш эмэгтэйчүүдийн төрөлд:
-Тэргүүн байрт цэрэгжлийн спортын мастер, ахлах ахлагч Б.Цацрал (016)
-Дэд байрт цэрэгжлийн спортын мастер, ахлах ахлагч Х.Давааням (013)
-Гутгаар байрт спортын мастер, ахлах ахлагч Ц.Отгонтөгс (032) нар шалгарсан юм.

Цогцолбор тэмцээний эмэгтэй тамирчдын багийн төрлөөр тэргүүн байрт хурандаа Ж.Мөнхбаяр захирагчтай Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл,



дэд байрт хурандаа Ч.Эрдэнэболд захирагчтай Зэвсэгт хүчний 013 дугаар анги, гутгаар байрт хурандаа Ш.Цэрэнбат захирагчтай Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн тамирчид шалгарч, бусдыгаа тэргүүлэв.

Эрэгтэй тамирчдын багийн төрлөөр тэргүүн байрт хурандаа Ш.Гантулга захирагчтай Зэвсэгт хүчний 015 дугаар анги, дэд байрт хурандаа Б.Олзбаяр захирагчтай Зэвсэгт хүчний 150 дугаар анги, гутгаар байрт хурандаа Ж.Сүх-Очир захирагчтай Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн тамирчид шалгарч, шагналаа гардан авсан юм.

Шагнал гардуулах ёслолын дараа хурандаа Д.Цог-Эрдэнэ тамирчдад хандаж хэлсэн үгэндээ Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын баг тамирчид нэгэн жигд оролцож, хүчтэй өрсөлдөгч байж чадлаа. Ялангуяа, хугацаат цэргийн алба хаагч, цэргийн гэрээт алба хаагчид офицер, ахлагч нартай эн тэнцүү өрсөлдөж, бүр медалийн тавцанд гарсан явдалд баяртай буйгаа илэрхийлээд энэ бол цэргийн сургалт бэлтгэл, биеийн тамирын тогтолцоо зөв гольдролоор явагдаж байгаагийн илэрхийлэл гэв.

Мөн тэрээр Зэвсэгт хүчний 325, 186 дугаар ангиудын тамирчдыг тэмцээнд өндөр ач холбогдол өгч, холоос хүрэлцэн ирж оролцсоныг онцолж, Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн тамирчдыг энэ жил одтой, сайн бэлтгэгдсэн байсныг цохон тэмдэглэв.

ЗХЖШ-ын орлогч дарга хурандаа Т.Галбадрах тэсгим өвлийн хүйтэнд цэргийн хүний бэлтгэгдсэн байдал болон тэсвэр хатуужил, эр зоригийг харуулсан тамирчдад баяр хүргээд "Энэ тэмцээнд та бүхэн бүгдээрээ ялагч. Цаг агаарын хүнд нөхцөлд огтхон ч ажрахгүй үүргээ гүйцэтгэж байгаа нь та бүхний хамгийн чухал амжилт. Үүгээр тань бид бахархаж байна" гээд баг тамирчдаа бэлтгэн оролцуулсан Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн удирдлагад талархал илэрхийллээ.

Энэхүү тэмцээнээс цэрэгжлийн спортын мастер 4, цэрэгжлийн спортын дэд мастер 8, цэрэгжлийн спортын I, II, III зэргийг 25, нийт 37 тамирчин цол, зэрэг хүртэж, цанаа тэврээд гэр гэртээ харилаа.

Зэвсэгт хүчний аварга 2023 оны аварга шалгаруулах тэмцээн ирэх долоо хоногт гийр өргөлт, гардан тулаан, цэрэгжлийн гимнастикаар үргэлжилнэ.

Ахмад Д.БОЛОР